



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/527

Булган сум

**Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9 дэхь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын чанартай замаас Жаргалант хүүхдийн зуслан хүртэлх орон нутгийн чанартай авто замын засварын ажилд шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгөөр “Булган АЗЗА” ТӨХК-тай гэрээ байгуулах эрхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, эрх олгогдсон хөрөнгийг хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахыг “Булган АЗЗА” ТӨХК захирал (М.Мөнх-Эрдэм)-д үүрэг болгосугай

3. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д даалгасугай.

4. Дээрх ажлын хөрөнгийг аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд батлагдсан “Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар” зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



8324610700